НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

# ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.НЯМБАТЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | - | 1 | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 1 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилт 94 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж, биелэлтийг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэв. | 05-12 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | - | 1 | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 2024 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтээр гарган 90 хувиар үнэлэгдэж, тайланг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. | 03-12 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 1.3.** Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | - | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт 100 хувиар үнэлэгдэж, тайланг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. | 11-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | **Арга хэмжээ 1.4.** Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | - | 1 | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамраарах, тайлагнах зорилт, арга хэмжээний хэрэгжилт байхгүй. | - | 90 |
| 5. | **Арга хэмжээ 1.5.** Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 1 | 1 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор баталсан Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 93.3 хувиар үнэлэгдэж, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилт түвшингийн тайлангийн хамт тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. | 01-12 | 100 |
| 6. | **Арга хэмжээ 1.6.** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 1 | 1 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 5 зорилтын 10 арга хэмжээний биелэлт 97,2 хувиар үнэлэгдэж, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилт түвшингийн тайлангийн хамт тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. | 05-12 | 100 |
| 7. | **Арга хэмжээ 1.7.** Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 1 | 2 | Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 1 зорилтын 18 арга хэмжээний хэрэгжилт 95,2 хувиар үнэлэгдэж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд https://control.ulaanbaatar.mn/app нийслэлийн нэгдсэн хяналт шинжилгээ, үнэлгээний системээр улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар тайлагнаж мөн тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилт түвшингийн тайлангийн хамт тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. | 04-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | **Арга хэмжээ 1.8.**<br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд 2024 онд байгуулсан гэрээний хүрээнд Нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 1 | 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд 2024 онд байгуулсан гэрээний хүрээнд Нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 2 зорилтын 9 арга хэмжээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган нэгтгэн 2024 оны жилийн эцсийн байдлаар 89 хувиар үнэлэгдэж, тайланг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. | 04-11 | 100 |
| 9. | **Арга хэмжээ 1.9.**<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс байгууллагын чиг үүрэгт хамраарах заалтыг хяналтад бүртгэх, биелэлтийг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана.<br>✓ Монгол Улсын хууль<br>✓ Улсын Их Хурлын тогтоол<br>✓ Улсын Их Хурлын Байнгын<br>✓ хорооны тогтоол<br>✓ Ерөнхийлөгчийн зарлиг<br>✓ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл<br>✓ Засгийн газрын тогтоол<br>✓ Ерөнхий сайдын захирамж<br>✓ Засгийн газрын хуралдааны тэмдэглэл<br>✓ Засгийн газрын албан даалгавар | тогтоол, шийдвэрийн хэрэгжилт-ийн тайлангийн тоо | 12 | 12 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэмдэглэлийн 1 заалт, Монгол Улсын Засгийн газрын 4 тогтоолын 6 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 1 заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврын 1 заалт нийт 9 заалтыг байгууллагын хяналтад бүртгэж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 2024 оны жилийн эцсийн байдлаар 98,8 хувиар үнэлэгдэж 12 удаагийн тайлан мэдээг нэгтгэж тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын “2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврыг нийслэлд зохион байгуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 2 арга хэмжээний биелэлтийн тайланг гаргаж тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 10. | **Арга хэмжээ 1.10.**<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын | Хүргүүлсэн захирамж-лалын баримт бичгийн хэрэгжилт-ийн | 4 | 4 | Нийслэлийн Засаг даргын 32 захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 5 хурлын тэмдэглэлийн 11 заалт, Нийслэлийн Засаг даргын 2 албан даалгаврын 18 заалтыг байгууллагын хяналтад бүртгэж, 2024 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 98,6 хувь, Нийслэлийн Засаг даргын | 04-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын чиг үүрэгт хамаарах заалтыг бүртгэх, шилжүүлэх, биелэлтийг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | тайлангийн тоо | | | зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 97 хувь, Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилт 98,7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тайлан мэдээг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэн тайлагнасан. | | |
| 11. | **Арга хэмжээ 1.11.** Төсвийн Ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулах 2024 оны “Хариуцлагын гэрээ”-ний төслийг боловсруулж, батлуулна. | Батлуулсан гэрээний тоо | 1 | 1 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас газрын даргатай байгуулах 2024 оны “Хариуцлагын гэрээ”-г Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хүнд суртал, чирэгдэлгүй ажиллах зэрэг 6 бүлэг 38 заалтаар боловсруулан батлуулсан. | 01-03 | 100 |
| 12. | **Арга хэмжээ 1.12.** “Хариуцлагын гэрээ”-ээр төсвийн шууд захирагчийн хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 2 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас газрын даргатай байгуулсан 2024 оны “Хариуцлагын гэрээ”-ний биелэлтийг хангах үйл ажиллагааны 24 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар 87 хувь, жилийн эцсийн байдлаар 96,6 хувийн гүйцэтгэлтэй үнэлгдэн тайланг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. | 05-12 | 100 |
| 13. | **Арга хэмжээ 1.13.** Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Батлуулсан төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулсан. | 01-03 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14. | **Арга хэмжээ 1.14.** Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 2 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7 зорилтын 43 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар 80 хувь, жилийн эцсийн байдлаар 97,2 гүйцэтгэлтэй үнэлэгдэн тайланг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлж тайлагнасан. | 05-12 | 100 |
| 15. | **Арга хэмжээ 1.15.** Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 4 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/155 дугаар захирамжаар батлуулсан газрын дүрмээр хүлээсэн 15 үндсэн чиг үүргийг хэрэгжилтийн тайланг улирал бүр гаргаж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 94,6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тайланг тогтоосон хугацаануудад Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэн тайлагнан ажилласан. | 02-12 | 100 |
| 16. | **Арга хэмжээ 1.16.** Байгууллагын үйл ажиллагааны сарын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 12 | 12 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу байгууллагаас сар бүр хийх ажлын төлөвлөгөөг тухай бүр боловсруулан батлуулж, байгууллагын үйл ажиллагааны сарын тайлангуудыг нэгтгэн гаргаж тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлж тайлагнасан. | 01-12 | 100 |
| 17. | **Арга хэмжээ 1.17.** Байгууллагын үйл ажиллагааны эхний хагас жил, жилийн тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 2 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дауу байгууллагын үйл ажиллагааны 2024 оны үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлж тайлагнасан. | 06-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18. | **Арга хэмжээ 1.18.** Байгууллагаас тухайн онд шинээр санаачилсан, шинэлэг ажлын тайланг гаргаж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 2 | Хөгжлийн бодлогын баримт бичгүүд, байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажлын тайланг жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж байна. | 06-12 | 90 |
| 19. | **Арга хэмжээ 1.19.** Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан батлуулж, тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 2 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 01 дүгээр удирдамжийн дагуу Нийслэлийн Дотоод аудитын албанаас байгууллагын 2022, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг нэгтгэж 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/221 дугаар албан бичгээр Нийслэлийн Дотоод аудитын албанд хүргүүлсэн.<br>Мөн Нийслэл дэх Төрийн аудитын газраас байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, зөвлөмжийн тайланг нэгтгэж 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 01/433 дугаар албан бичгээр Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн. | 05-11 | 100 |
| 20. | **Арга хэмжээ 1.20.** Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана. | Цахимаар тайлагнасан тоо | - | 12 | Нийслэлийн удирдах ажилтнуудын 17 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах 51 үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь нийслэлийн https://erp.ulaanbaatar.mn/ портал нэгдсэн системийн Хяналт шинжилгээ, үнэлгээний дэд системээр тайлагнасан. | 01-12 | 100 |
| **Зорилт 2.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.** Албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, заавар, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэнэ. | Шийдвэр-лэлтийн хувь | 95% | 95% | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, албан хэрэг хөтлөлтөд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу баримт бичгийг хөтөлж, албан тушаалын чиг үүрэгтэй холбоотой шилжиж ирсэн хариутай 11 албан бичиг, хариугүй 14 албан бичиг нийт 25 албан бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэж, 22 албан бичгийг холбогдох журам, | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | стандартын дагуу боловсруулж явуулсан. Албан бичиг шийдвэрлэлт 100 хувь, 5.12 үзүүлэлттэй, зөрчил тооцогдсон, хугацаа хоцроож шийдвэрлэсэн албан бичиг байхгүй. | | |
| 2. | **Арга хэмжээ 2.2.** Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны хадгаламжийн нэгж үүсгэж, тогтоосон хугацаанд хүлээлгэн өгнө. | Хадгаламж-ийн нэгжийн тоо | 10 | 10 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны цаасан суурьт байнга хадгалах 16, түр хадагалах 4 нийт 20 архивын хадгаламжийн нэгж үүсгэн 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн. | 01-03 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 2.3.** Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар өгсөн үүрэг даалгавар бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллана. | Үйл ажиллагаа-ны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Газар, хэлтсийн дарга болон газрын хурлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтээс албан тушаалын чиг үүрэгт хамаарах үүрэг даалгаврыг тухай бүр бүрэн хэрэгжүүлж, цаг хугацаанд нь тайлагнасан. | 01-12 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийнхувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.** БНХАУ-ын Жиамуси, Харбин хотуудад томилолтоор ажиллах | Хүргүүлсэн илтгэх хуудсны тоо | - | 1 | Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2023 оны Б/84 дүгээр тушаалын дагуу Хятад, Орос, Монгол 3 улсын хотуудын өвлийн аялал жуулчлал, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор БНХАУ-ын Хэйлунжянь мужийн Жиамуси хотноо 2024 оны 01 дүгээр сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Жиамуси" Хятад, Орос, Монголын анхны мөс, цасны соёлын салбарын өндөр хэмжээний олон улсын чуулга" уулзалтад оролцон Улаанбаатар хотын талаар танилцуулга хийж, томилолтоор ажилласан тухай Илтгэх хуудсыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт хүргүүлсэн. | 01-01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.** Нийслэлийн аялал жуулчлалын ерөнхий стратеги танилцуулга мэдээлэл гаргаж хүргүүлэх | Хүргүүлсэн танилцуулга мэдээллийн тоо | - | 1 | Нийслэлийн Аялал жуулчлалын ерөнхий стратеги, жуулчдын статистик мэдээлэл, тоон үзүүлэлт, жуулчдын зорин очиж үздэг түүх, соёл, шашны дурсгалт газруудын товч тайлбар зэрэг 3 бүлгийн хүрээнд танилцуулга, мэдээлэл гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт албан бичгээр хүргүүлэв. | 03-03 | 100 |
| 3. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.** Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үндсэн чиг үүргийн хүрээнд зохион байгуулах эвент, арга хэмжээнүүдийг зохион байгуулахад оролцох | Оролцсон эвент, үзэсгэлэн арга хэмжээнийй тоо | 3 | 6 | Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээ, байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан “Улаанбаатар өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Талын салхи” олон улсын мото наадам, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фууд фестиваль” зэрэг 6 арга хэмжээний бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хариуцсан ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэв. | 01-08 | 100 |
| 4. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.** Бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд оролцох | Цэвэрлэгээний ажилд оролцсон тоо | 1 | 2 | Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын баталсан “Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ” арга хэмжээг зохион байгуулах ажлын удирдамж, хуваарийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 12, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бүх нийтийн цэвэрлэгээний ажилд алба хаагчдын хамт оролцсон. | 04-05 | 100 |
| 5. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.** Хаврын бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэн “Жуулчин төгөл”-д мод тарих | Мод тарих ажилд оролцсон тоо | - | 1 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон хот-Иргэний оролцоо” 2024 оны хаврын мод тарих арга хэмжээ 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулагдаж “Жуулчин төгөл”-д тарьсан модны арчилгаа, цэнэг усалгаа нөхөн тарилтыг хийх, шинээр мод тарих ажилд оролцож 180 мод суулгах, тарих ажлыг зохион байгууллаа. | 05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "UB FOOD FESTIVAL-2024" арга хэмжээний бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хөгжим техник, тайз дэлгэц, талбайн тохижилт, асар, аюулгүй байдал зэрэг хариуцсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | | |
| 9. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9.** "Тохижилт бүтээн байгуулалтын жил"-ийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэх | Тайлангийн тоо | - | 1 | Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар 2024 оныг "Тохижилт бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбогдуулан арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, тайланг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлж тайлагнасан. | 06-12 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Хариуцсан чиглэлийн хүрээнд сургалт, семинарт, зөвлөгөөнд хамрагдаж тухай бүр мэдлэг чадвараа дээшлүүлнэ. | Хамрагдсан сургалтын тоо | 6 | 8 | "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй", "E-Doc системийн хэрэглээ", "Хууль эрх зүй-Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Өөрчлөлтийн менежмент", "Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх" нь Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 зэрэг сэдэвт 7 удаагийн танхимын сургалт, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдаг | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7-4-10 цахим сургалтад 6 удаа хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. | | |
| 2. | Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны сургалтад хамрагдана. | Гэрчилгээ | - | 1 | "Худалдан авах ажиллагааны хөтөч" сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх 3 өдрийн сургалтад хамрагдан шалгалтад тэнцэн 2024/0820 гэрчилгээ авсан. | 01-03 | 100 |
| 3. | Солонгос хэлний сургалтад хамрагдаж хэлний мэдлэг чадвараа дээшлүүлнэ. | Цаг | - | 72 | Нийслэлийн Аялал жуулчлалын газар, "Койка" олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж буй Солонгос хэлний сургалтад хэлний мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор хамрагдаж 7 хоног бүрийн 1, 3, 5 дахь өдрүүдэд сургалтад хамрагдаж хэлний мэдлэгээ дээшлүүлсэн. | 01-06 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН О.НЯМБАТ

2024 оны 12 дугаар сарын 05.